

ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № 00601

2020 оны 12 сарын 24 өдөр

Байгууллагын нэр: Эрүүл мэндийн яам	Дансны дугаар	Дүн тоогоор
Регистрийн дугаар: 9087443	100900020001	178,360,000.00
Хүлээн авагчийн нэр: Баянгол Мед ХХК	Дансны дугаар	
Регистрийн дугаар: 2869225	475006054	
Хүлээн авагчийн банк: Худалдаа Хөгжлийн Банк		
Мөнгөн дүн үсгээр: Нэг зуун далан найман сая гурван зуун жаран мянган төгрөг	Ангилал	
Гүйлгээний утга: ЭМДТөв-д шаардлагатай тон.төх багц /Багц-3/ Г.Бат-эрдэнэ	71601 - Нийгмийн эрүүл мэнд 81605 - Эрүүл мэндийг дэмжих 0000 - Төрийн сан 210601 - Багаж, техник, хэрэгсэл 157,660,000.00 81609 - Эрүүл мэндийн үндэсний бусад хөтөлбөрүүд 0000 - Төрийн сан 210801 - Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээни 20,700,000.00	
Хяналтын хуудас №: 00601		
Үндэслэх бичиг баримтын нэр	Үндсэн баримтын он сар дугаар	Төрийн сангийн тэмдэглэл
1.Нэхэмжлэх	2020.12.03	
2.Зарлагын баримт	2020.12.03	
3.Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт 87/2020	2020.12.02	
4.ТНБД-ын Үнэлгээний хорооны тушаал А/86	2020.09.09	
5.Төндөрийн үнэлгээний тайлан	ЭМЯ/2020/09/17	
6.Тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ №363	2020.10.29	

Тамга

Гарын үсэг

Дарга

Нягтлан бодогч


Я.Амаржаргал

Э.Эрдэнэцэцэг


Төрийн санд гүйлгээ хийсэн

.....оны.....сарын.....өдөр

Тэмдэг, гарын үсэг



БАТЛАВ:



**ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
/БАГЦ-№7 УРЬДЧИЛСАН СЭРГИЙЛЭХ ОНОШИЛГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ/
НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № **363**

Улаанбаатар хот

Нэг талаас “ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “БАЯНГОЛ МЕД” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж Багц-№7: “Урьдчилсан сэргийлэх оношилгооны тоног төхөөрөмж”-ийг нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 178,360,000₮ /Нэг зуун далан найман сая гурван зуун жаран мянга/ төгрөгөөр Улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлнэ. 2020 онд санхүүжих дүн 178,360,000₮ /Нэг зуун далан найман сая гурван зуун жаран мянга/ төгрөгийг тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсний дараа нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк	Тоо ширхэг
	1	2	3	4
1	Спирометр	Итали	Spirolab	5
2	Биеийн бүтэц тодорхойлох аппарат	БНХАУ	ВУН	5
3	Автомат жин, өндөр хэмжигчтэй	БНХАУ	ВУНJ	5

4	Ясны сийрэгжилт тодорхойлох аппарат	БНХАУ	OsteoKJ	6
---	-------------------------------------	-------	---------	---

5. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хүчин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож, зөвшилцөн шийдвэрлэнэ.

6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Бусад шаардлагатай баримт бичиг;
Тендерийн баталгаа;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь;
Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/
Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

7. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

 Д.Нарантуяа
Хуулийн хэлтсийн дарга

 М.Ганзориг

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий менежер

 Ц.Төгөлдөр

Ахлан нягтлан бодогч

 Э.Алтанзул

Хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга



Т.Бямбасүрэн

Хуулийн хэлтсийн гэрээний
мэргэжилтэн



Д.Мөнхцэцэг

Хөрөнгө оруулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн



Г.Бат-Эрдэнэ

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн
газрын VIII байр, 1 давхар 106 тоот
өрөө Улаанбаатар-48, Олимпын
гудамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

Хаяг: Баянгол Дүүрэг, 11-р хороо,
Эх нялхасын гудамж, 21/А байр
Утас: 976-7010-1313
И-мэйл: info@bayangolmed.mn
Дансны дугаар: 475006054
Худалдаа, хөгжлийн банк

**ТЕХНИКИЙН КОМИССЫН УРЬДЧИЛСАН
ДҮГНЭЛТ**

2020 оны 12 дугаар сарын 02

№ 84/2020

Улаанбаатар хот

НЭГ.

1.1 Гэрээний нэр, дугаар, огноо: **Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж, Багц 7: Урьдчилсан сэргийлэх оношилгооны тоног төхөөрөмж нийлүүлэх, №363**, 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдөр

1.2 Тоног төхөөрөмжийн нэр: **Багц 7. Урьдчилсан сэргийлэх оношилгооны тоног төхөөрөмж**

1.3 Захиалагч байгууллага: **Эрүүл мэндийн яам**

1.4 Нийлүүлэгч байгууллага: **“Баянгол мед” ХХК**

1.5 Эрүүл мэндийн сайдын 2018 оны **A/317** дугаар “Техникийн комисс шинэчлэн байгуулах, журам батлах тухай” тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг гэрээний хавсралт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, барааны чанар, тээвэрлэлт, хадгалалтын байдал болон тоног төхөөрөмжийн холбогдох баримтуудыг үндэслэн багаж, тоног төхөөрөмжийн марк, модель, техник үзүүлэлт таарч буй эсэхэд шалгаж техникийн комиссын урьдчилсан дүгнэлтийг гаргав.

ХОЁР.

2.1 Гүйцэтгэгч байгууллага гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдөр “Баянгол мед” ХХК-ны агуулахын байранд очиж үзсэн бөгөөд баримт бичигтэй тулгалт хийж үзээд, ажлын хэсэг хүлээн авагч эрүүл мэндийн байгууллагуудын ашиглалтад хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэв.

2.2 Гүйцэтгэгч захиалагчаас өгсөн багаж, тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудад хүргэж, суурилуулж, ашиглалтын сургалтыг явуулж, 2 жилийн хугацаанд баталгаат засварыг бүрэн хариуцаж, сэлбэг хэрэгслээр хангана.

2.3 Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт, холбогдох баримт бичиг, материалыг 3 хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч, хүлээн авагч байгууллага тус бүрт 1 хувийг хүргүүлнэ.

2.4 Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт
- Баталгаат засварын хугацаа, үйлчилгээ, тохиргооны батлагдсан хуваарь

ГУРАВ. БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮНЭ, ТОО ШИРХЭГ

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк, модель	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Спирометр	Итали	Spirolab	5	9,088,000	45,440,000
2	Биеийн бүтэц тодорхойлох аппарат	БНХАУ	ВУН	5	2,880,000	14,400,000
3	Автомат жин, өндөр хэмжигчтэй	БНХАУ	ВУНJ	5	448,000	2,240,000

4	Ясны сийрэгжилт тодорхойлох аппарат	БНХАУ	OsteoKJ	6	19,380,000	116,280,000
НИЙТ						178,360,000
Нэг зуун далан найман сая гурван зуун жаран мянган төгрөг						

ДӨРӨВ. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Гэрээнд тусгагдсан техник үзүүлэлт	Шаардлага хангасан эсэх
1. Спирометр Үйлдвэрлэсэн улс: Итали Үйлдвэрлэгч: MiR Загвар: Spirolab ШААРДЛАГА ХАНГАЖ БУЙ ЭСЭХ: ТИЙМ		
	- Хэмжих параметр: FVC, FEV1, FEV1/FVC%, FEV 3, FEV3/FEV%, FEV6, FEV1/FEV6%, PEF, FEF25%, FEF50%, FEF75%, FEF25-75%, FET, Vext, Уушигны нас, FIVC, FIV1, FIV1/FIV%, PIF, VC, IVC, IC, ERV, FEV1/VC%, VT, VE, Rf, ti, te, ti/t-tot, VT/ti, MVV - Цахилгаан тэжээл: 220В/50Гц, дахин цэнэглэгддэг батарейтай - Температур: хагас дамжуулагч 0-450C - Урсгал мэдрэгч: хос чиглэлийн дижитал турбинтай - Урсгалын хэмжээ: ±16л/сек, эзэлхүүний нарийвчлал: ±3% эсвэл 5:0 мл - Холболт: USB, RS232, Bluetooth - Дэлгэц: FSTN график, 800 x 480 пиксель 7инч LCD дэлгэц - Хэвлэгч/цаас: дулааны, 4.4 инч (112мм) өргөн - Амны зуултуур: 30мм	Хангасан
2. Биеийн бүтэц тодорхойлох аппарат Үйлдвэрлэсэн улс: БНХАУ Үйлдвэрлэгч: Zhongshan Bery & Electronics Co.,Ltd Загвар: BYN ШААРДЛАГА ХАНГАЖ БУЙ ЭСЭХ: ТИЙМ		
	- Зориулалт: Биеийн найрлага буюу биен дэх өөх, ус, уураг, эрдэс, булчингийн кг ба хувийг тодорхойлдог - Биеийн жингийн индекс, бэлхүүснээс гуя хүртэлх харьцааг гаргадаг - Дэлгэц: 900x900 digital screen - Хэмжилт хийх хугацаа: 40 сек - Оруулж болох өндөр: 10~200см - Хэмжилтийн жин: 5~200кг - Цахилгаан тэжээл: 220В/50Гц байх - Зориулалтын программ хангамж дагалдуулсан байх RS232 холболттой	Хангасан
3. Автомат жин, өндөр хэмжигчтэй Үйлдвэрлэсэн улс: БНХАУ Үйлдвэрлэгч: Zhongshan Bery & Electronics Co.,Ltd Загвар: BYNJ ШААРДЛАГА ХАНГАЖ БУЙ ЭСЭХ: ТИЙМ		
	250 кг хүртэл даацтай - Тоон үзүүлэлттэй /дигитал/ LCD дэлгэцтэй - Өндөр хэмжигчийн 83-210мм боломжтой	Хангасан
4. Ясны сийрэгжилт тодорхойлох аппарат Үйлдвэрлэсэн улс: БНХАУ Үйлдвэрлэгч: Nanjing wejin industrial Co.,Ltd		


Загвар: OsteoKJ ШААРДЛАГА ХАНГАЖ БҮЙ ЭСЭХ: ТИЙМ	
• Хэт авиад суурилан ясны сийрэгжилт тодорхойлдог • Шинжилгээ хийх байрлал: Өсгий • Шинжилгээний үзүүлэлтүүд: T-score, Z-score, OI, T-ratio, Z-ratio, BMI, Height prediction • Хэт авиан параметр: BUA-Broadband ultrasound attenuation, SOS-Speed of Sound, OI – Osteoporosis Index • Шинжилгээний хугацаа 15 секундээс ихгүй • Ус хэрэглэхгүй датчик /Waterless probe/ • Өөр дээрээ компьютер болон хэвлэгчтэй /Built in computer and thermal printer/ • 10.1 инч мэдрэгчтэй өнгөт TFT, LCD дэлгэцтэй • Бүх төрлийн дэлгэц, компьютерын товчлуур, хулгана, хэвлэгчид холбогдох боломжтой. /USB, HDMI, VGA/	Хангасан

ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ:

1. Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж, Багц 7: Урьдчилсан сэргийлэх оношилгооны тоног төхөөрөмж нийлүүлэх, №363 гэрээний дагуу нийлүүлэгдэх 4 нэр төрлийн 21 тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийг гэрээнд тусгагдсан үзүүлэлттэй тулгаж үзэхэд шаардлага хангаж байна.
2. Ханган нийлүүлэгч байгууллагын зүгээс:
 - Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол хэл дээр бэлтгэн хүлээн авагч байгууллагад өгөх.
 - Гэрээнд заагдсан дагалдах хэрэгслийн тоо ширхэг, нэр төрлийн дагуу хүлээлгэн өгөх.
 - Холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээний сургалт зохион байгуулах шаардлагатай.
3. Ашиглагч байгууллагын зүгээс:
 - Гэрээнд заагдсаны дагуу тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгслийн тоо ширхэг, нэр төрлийн дагуу мөн холбогдох баримт бичиг, мөн техник үзүүлэлтэд тусгагдсан тухайн тоног төхөөрөмжийн програм хангамж, функцийг нэг бүрчлэн хүлээж авах шаардлагатай


УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

Техникийн комиссын дарга:

ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга  Н.Гэрэлт-Од


Нарийн бичгийн дарга:

ЭМЯ-ны ЭУТГазрын Эрүүл мэндийн техник, тоног төхөөрөмж, хэмжлийн нэгдмэл байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн

 Б.Сансармаа

Гишүүд:

ЭМЯ-ны ЭЗСХОГазрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

 Г.Бат-Эрдэнэ